



IMS INSTITUTE OF
MANAGEMENT
AND SKILL
MANAGEMENT CONSULTING SERVICE

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он



ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Захиалагч: Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар

Гүйцэтгэгч: “Менежмент ба ур чадварын хүрээлэн” НҮТББ

Улаанбаатар хот

2025 он

ӨМНӨХ ҮГ

Энэхүү судалгааг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын захиалга, санхүүжилтээр гүйцэтгэсэн хэдий ч тус байгууллага нь энэхүү судалгааны тайланд тусгагдсан мэдээлэл, дүгнэлтийн үнэн бодит байдал, түүнчлэн хэвлэлийн алдаанд хариуцлага хүлээхгүй болно. Багахангай дүүргийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох, түүнчлэн тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын зүгээс бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, дүүргийн дотоод үйл ажиллагааны чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай холбоотой тус дүүргийн төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн талаарх судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, үр дүнг тооцох, тайлан бэлтгэх үйл ажиллагааг хараат бус байдлаар, зөвхөн ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Менежмент ба ур чадварын хүрээлэн” НҮТББ-ын судлаач нар гүйцэтгэсэн бөгөөд Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хувийн сонирхлоор оролцоогүй, зөвхөн иргэдэд болон алба хаагчдад мэдээлэл хүргэх, дүүргийн нөхцөл байдалтай холбогдох асуудлаар мэдээлэл ирүүлэх хэлбэрээр хамтран ажилласан болно.

Энэхүү тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмж нь иргэдийн болон төрийн албан хаагчдын дунд санамсаргүй түүврийн хэлбэрээр явуулсан судалгаанд үндэслэн боловсруулагдсан бөгөөд уг тайланд тусгагдсан тоо, статистикийг албан хаагчийг буруутгах буюу аливаа төрлийн сахилгын зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд нотлох баримт болгон ашиглахгүй.

“МЕНЕЖМЕНТ БА УР ЧАДВАРЫН ХҮРЭЭЛЭН” НҮТББ

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт.....	4
Графикийн жагсаалт.....	6
Удиртгал.....	7
Гадаад орчны шинжилгээ.....	11
Дотоод орчны шинжилгээ.....	21
Дүгнэлт.....	29
Зөвлөмж.....	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Судалгаанд хамрагдсан иргэдийн мэдээлэл, жагсаалт

Хүснэгт 1.2. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.3. Иргэдийн амжиргааны түвшинд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.4. Иргэдийн зүгээс төрийн албанд итгэх байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.5. Иргэд хооронд харилцааны байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.6. Нийгмийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.7. Хууль сахиулах, аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.8. Дүүргийн удирдлагуудын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.9. Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.10. Эдийн засаг, татвар, бизнесийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 1.11. Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл, жагсаалт

Хүснэгт 2.2. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.4. Дүүргийн удирдлагын үйл ажиллагааны нээлттэй байдалд өгсөн үнэлгээ

Хүснэгт 2.5. Дүүргийн албан хаагчдын ур чадвар, шуурхай шударга байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.6. Дүүргийн албан хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг хангах байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.7. Иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд өгсөн үнэлгээ

Хүснэгт 2.8. Албан хаагчийг идэвхижүүлэх, мотивацийн байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Хүснэгт 2.9. Авлига, хүнд суртал, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.1.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.2.Иргэдийн амжиргааны түвшинд өгсөн үнэлгээ

График 1.3.Иргэдийн зүгээс төрийн албанд итгэх байдалд өгсөн үнэлгээ

График 1.4.Иргэд хоорондын харилцааны байдалд өгсөн үнэлгээ

График 1.5.Нийгмийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.6.Хууль сахиулах, аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.7. Дүүргийн удирдлагуудын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.8.Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.9.Эдийн засаг, татвар, бизнесийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.10 Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 1.11.Хамгийн их сэтгэл ханамжтай буюу сайн үнэлгээ бүхий салбар

График 1.12.Хамгийн бага сэтгэл ханамжтай буюу муу үнэлгээ бүхий салбар

График 2.1. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 2.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 2.4. Дүүргийн албан хаагчдын ур чадвар, шуурхай шударга байдалд өгсөн үнэлгээ

График 2.5. Дүүргийн албан хаагчдын эдийн засаг, нийгмийн байталгааг хангах байдалд өгсөн үнэлгээ

График 2.6. Иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд өгсөн үнэлгээ

График 2.7. Албан хаагчийг идэвхижүүлэх, мотивацийн байдалд өгсөн үнэлгээ

График 2.8.Авлига, хүнд суртал, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээ

График 2.9.Хамгийн их сэтгэл ханамжтай буюу сайн үнэлгээ бүхий салбар

График 2.10.Хамгийн бага сэтгэл ханамжтай буюу муу үнэлгээ бүхий салбар

УДИРТГАЛ

Манай улс 1992 оноос ардчиллын үзэл санаанд тулгуурласан нийгмийн томоохон өөрчлөлтийг нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан, төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр төрийн үндсэн үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ дүгнэлт хийлгэж, алдаа оноогоо дэнсэлж хэвшиж байгаа нь сайшаалтай.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4.13, 4.14 дэх хэсэгт заасны дагуу салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ хийх ба уг судалгааг хөндлөнгийн судалгааны байгууллагаар хийлгэхээр журамласан тул энэхүү судалгаа нь дээрх хууль, тогтоомжийн хүрээнд хийгдсэн болно.

Энэхүү судалгааг хийсэн “Менежмент ба ур чадварын хүрээлэн” НҮТББ нь 2016 онд үүсгэн байгуулагдсанаас хойш ISO 9001 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартыг нэвтрүүлэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд уг стандартын нэг чухал функц болох хэрэглэгчийн үнэлгээг хийх судалгааны ажлыг уг стандартын сургалтыг зохион байгуулдаг, түүнчлэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагын төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн, судлаачдын багаар гүйцэтгүүлдэг онцлогтой болно.

Судалгааг эрх зүйч, төрийн захиргааны менежмент, мэргэшсэн болон ахлах аудитор зэрэг мэргэжил, мэргэшилтэй судлаачид удирдан явуулсан бөгөөд асуумжийн болон фокус ярилцлагын зэрэг шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны аргын дагуу бэлтгэлээ.

Судалгааны үндэслэл, шаардлага

Сүүлийн жилүүдэд төрийн байгууллага, албан хаагч ялангуяа улс төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэл, хууль бус шинжтэй өдөөн хатгалга, турхиралт хийх, ард иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлж байгаа гэх нэрийдлээр олон нийтэд буруу ташаа мэдээлэл түгээх замаар өөрсдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилго бүхий этгээдүүдийн ёс суртахуунгүй үйлдлийн улмаас төрийн албан хаагчдын ажилдаа хандах хандлага сулрах, улс төрийн болон нийгмийн зүгээс ирэх дарамт шахалт, иргэдийн дунд албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл хийх, түүнчлэн тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд айдасгүй амьдрах боломж, нөхцлийг бүрдүүлэх, энэ чиглэлээр иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх, төрийн байгууллагад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд энэхүү судалгаа онцгой ач холбогдолтой.

Судалгааны зорилго, зорилт

Багахангай дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгч буюу дүүргийн оршин суугч иргэд хэрхэн үнэлж байгаа талаарх “гадаад орчны шинжилгээ”, түүнчлэн тус

дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын зүгээс бусад байгууллагад чиглэсэн үйл ажиллагааг төрийн албан хаагчдын зүгээс хэрхэн үнэлж байгаа талаарх “дотоод орчны шинжилгээ”-г тус тус үнэлэх, судалгааны аргачлалыг боловсруулах, уг аргачлалын дагуу судалгаа явуулан, дүгнэлт хийх, дүүргийн удирдлагын зүгээс цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Багахангай дүүргийн удирдлага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж, зөвлөмж боловсруулах;
2. Тус дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлж, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судалгааны ажлын онцлог

Энэ чиглэлээр, бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын урьд өмнө хийгдсэн судалгаанууд нь ихэвчлэн санхүүгийн аудит хийх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, мэргэжлийн бус судлаач нараар хийлгэсэн байх бөгөөд судалгааны аргын хувьд тухайн нэгжийн үйл ажиллагааны тайланд дүгнэлт хийх замаар боловсруулснаас гадна ихэнх тохиолдолд санал асуулга явуулахгүйгээр, зөвхөн судлаачийн зүгээс дүгнэлт хийж, зөвлөмж өгсөн байна. Энэхүү судалгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглан, төрийн захиргааны чиглэлээр мэргэшсэн судлаачдын боловсруулсан судалгааны аргачлал, загварын дагуу явуулснаараа онцлогтой болно.

Судалгааны арга зүй

Иргэдийн болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох уг судалгааны мэдээллийг тоон арга болох асуулгын аргыг ашиглан, санамсаргүй түүврийн хэлбэрээр, төрийн албан хаагчдын дунд цахимаар, иргэдийн дунд цахимаар болон цаасан суурьтай хэлбэрээр цуглуулав. Судалгааны үр дүнг баталгаажуулах, “гажилт” буюу буруу ташаа мэдээлэл ирүүлсэн байдлыг хянах зорилгоор зарим иргэдийн дунд фокус бүлгийн ярилцлагын аргыг хослуулан, үр дүнг нэгтгэлээ.

Асуулгыг боловсруулахдаа Лайкертын хэмжээс (Likert's scale)-ийг ашигласан. Уг хэмжээс нь судалгаанд хамгийн өргөн хэрэглэгддэг тоон систем бөгөөд “шкал” буюу чанарыг тоогоор илэрхийлэх зорилго бүхий, тухайн объект, субъект, төлөв байдлын тоон хэмжигдэхүүн юм. Энэхүү хэмжигдэхүүнийг ихэнхидээ байгууллагын ажилчдыг хамарсан судалгааны хүрээнд явагддаг сэтгэлзүйг хэмжихэд ашигладаг ба уг тоон үзүүлэлт нь аливаа зүйлийг өөр хооронд нь харьцуулахгүйгээр тусгаарлан дүгнэж, тодорхойлдог арга тул иргэдийн зүгээс болон алба хаагчдын зүгээс төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлоход ашиглах бүрэн боломжтой гэж судлаачдын зүгээс үзсэн болно.

Түүврийн хэмжээ

Судалгааны түүвэрлэлтийг иргэд буюу “гадагш чиглэсэн”, төрийн албан хаагч буюу “дотогш чиглэсэн” гэсэн 2 бүлэгт хуваан авч үзсэн.

Иргэдийн судалгааны түүвэр: Энэхүү судалгааны түүврийн хэмжээг төлөвлөхдөө Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг албан ёсны тоо мэдээллийг ашигласан ба Багахангай дүүргийн хэмжээнд 4549¹ иргэн амьдарч байгааг онолын хувьд итгэлцлийн түвшин ~95 хувь, хүлцэх алдаа (margin of error) - +5 хувь гэж үзвэл 350-360 хүнийг хамруулахад хангалттай гэж үзсэн ба уг судалгаанд нийт 400 иргэн оролцсоноос 1 дүгээр хороонд амьдардаг 252, 2 дугаар хороонд амьдардаг 143, байнга оршин суудаггүй иргэн 5 тус тус хамрагдав.

Албан хаагчдын судалгааны түүвэр: Судалгаанд тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон нутгийн захиргааны байгууллагын 403 албан хаагч хамрагдсан нь түүврийн хэмжээ өндөр түвшинд буюу судалгааны үр дүнг гаргахад хангалттай гэж үзсэн болно.

Хэрэглэгчийн үнэлгээний дүнг тооцсон аргачлал

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны бүрдэл хэсэгт төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамж буюу гадаад орчны шинжилгээ, албан хаагчдын сэтгэл ханамж буюу дотоод орчны шинжилгээ гэсэн 2 дэд хэсэгт хамааруулж, санал асуулгын аргаар явууллаа. Санал асуулгын асуулт тус бүрийн хариултыг тухайн асуулгатай холбоотой үйл ажиллагаа сайн гэдэгтэй санал нийлэх байдлаар нь “Огт үгүй=1”, “Бага зэрэг=2”, “Дунд зэрэг=3”, “Их=4”, “Маш их=5” гэсэн хувилбар бүхий лайкертын хэмжүүрээр, 1-5 хүртэлх оноо өгч, тухайн оноог өгсөн оролцогчийн саналын тоогоор үржүүлж, гарсан дүнг судалгаанд оролцогчдын нийт тоонд хуваах байдлаар сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон тул “Дунд зэрэг” үнэлгээнд хамгийн ойр байгаа нь дундаж гэж үзэх, уг үзүүлэлтээс нэмэгдэх тусам сайн, багасах тусам муу гэж үзнэ.

Өөрөөр хэлбэл судалгааны тухайн асуултын дундаж 3,0-тай тэнцүү байгаа нь дундаж үнэлгээ 50 хувь буюу хамаарах асуумжид судалгаанд оролцогчдын **“сэтгэл ханамж дунд зэрэг”** гэж ойлгож болох бөгөөд уг дүн 5,0-д дөхөх тусам **“сэтгэл ханамжтай”**, харин дунджаас доош 1,0-д ойртох тусам **“сэтгэл ханамжгүй”** гэсэн үг юм.

Мэдээлэл цуглуулах, боловсруулах үе шат

Мэдээллийг боловсруулахдаа захиалагч буюу Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээ, удирдамжийн хүрээнд тус холбооны судлаачдын боловсруулсан аргачлал, асуумжийг бусад судлаачдад тодорхой мэдээллийг өгч, судалгаа явуулах аргачлал, цахимаар болон цаасан хэлбэрээр асуумж авах, фокус ярилцлага болон телефон утсаар холбогдож асуулт тавих зэрэг аргуудыг танилцуулсны дагуу энэхүү судалгааг боловсруулсан болно.

¹ https://www.1212.mn/mn/statcate/table-view/Population,%20household/1_Population%2C%20household/DT_NSO_0300_004V5.px

НЭГ. ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

1.1. Судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээлэл

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд цахимаар болон цаасан суурьтай хэлбэрээр нийт 400 иргэн оролцсоноос 1 дүгээр хороонд амьдардаг 252, 2 дугаар хороонд амьдардаг 143, байнга оршин суудаггүй иргэн 5 тус тус хамрагдав. Дээрх судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 120 буюу 30 орчим хувь нь тухайн тус дүүрэгт 26 буюу түүнээс дээш жил ажиллаж, амьдарсан иргэд байв.

Судалгаанд оролцогчдын насны хувьд 36-45 настай 180 буюу 45 хувь, 46-55 настай 110 буюу 27,5 хувийг тус тус эзэлж байгаа нь нас тогтсон, тухайн дүүрэгт удаан хугацаанд амьдарсан иргэд судалгаанд илүү идэвхитэй хамрагдсан байх ба мөн хүйсийн хувьд эрэгтэй 220 буюу 55 хувь, эмэгтэй 180 буюу 45 хувийг тус тус эзэлж байна.

Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой 131 буюу 32,5 хувь нь дээд, 209 буюу 52,5 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд судалгаанд илүү хамрагдсан байна.

Хүснэгт 1.1. Судалгаанд хамрагдсан иргэдийн мэдээлэл, жагсаалт

Үзүүлэлт	Шинж байдал	Тоо	Хувь
Нас	16-25 настай	32	8.0
	26-35 настай	22	5.5
	36-45 настай	178	44.5
	46-55 настай	108	27.0
	56-65 настай	31	7.8
	66-аас дээш	29	7.8
Боловсрол	Дээд	131	32.8
	Тусгай дунд	41	10.3
	Бүрэн дунд	209	52.3
	Бага	19	4.8
Хүйс	Эрэгтэй	220	55.0
	Эмэгтэй	180	45.0
Байнга оршин суудаг хаяг	1 дүгээр хороо	252	63.0
	2 дугаар хороо	143	35.8
	Бусад	5	1.3
Багахангай дүүрэгт амьдарсан хугацаа	0-5 жил	51	12.8
	6-10 жил	61	15.8
	11-15 жил	93	23.3
	16-20 жил	38	9.5
	21-25 жил	32	8.0
	26-аас дээш	120	30.0
	Байнга оршин суудаггүй	5	1.3

1.2. Дүүргийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн түвшин



Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, бүтээл туурвих, төрийг удирдах хэрэгт оролцох, эвлэлдэн нэгдэх, тэгш эрхтэй, халдашгүй чөлөөтэй, итгэл үнэмшилтэй байх зэрэг эрхүүдийг тодорхойлон тунхагласан. Төрийн байгууллага, албан тушаалтны хувьд иргэний энэхүү эрхийг хамгаалах үндсэн зарчмын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх шаардлага үүсдэг ба уг үйл ажиллагааны үр дүнг хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшингээр хэмждэг билээ.

Судлаачдын зүгээс судалгааны цар хүрээнд тохируулан, Багахангай дүүрэгт ажиллаж амьдарч буй иргэдийн дунд асуумж бөглүүлэх, ярилцлага хийх замаар тухайн дүүргийн удирдлага, түүнчлэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг хэрхэн үнэлж байгааг ерөнхийд нь тандаж, үр дүнг нэгтгэсэн.

Хүснэгт 1.2. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Багахангай дүүргийн удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагаа хуулийн хүрээнд, иргэдэд ээлтэй байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	400	Тоо	69	101	188	31	11
		Хувь	17.3	25.3	47.0	7.8	2.8
Оноо	3.5						



График 1.1. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.3. Иргэдийн амжиргааны түвшинд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Танай дүүргийн амьжиргааны түвшин сайн, иргэд нь боломжийн амьдардаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	400	Тоо	59	51	211	23	56
		Хувь	14.8	12.8	52.8	5.8	14.0
Оноо	3.1						


График 1.2.Иргэдийн амжиргааны түвшинд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.4.Иргэдийн зүгээс төрийн албанд итгэх байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Хэрэв аливаа нэг эрсдлийн улмаас Таны хууль ёсны эрх ашиг зөрчигдвөл дүүргийн удирдлага, холбогдох байгууллага зөрчигдсөн эрхийг сэргээж, шударга ажиллаж чадна гэдэгтэй Та санал нийлэх үү?	400	Тоо	32	127	152	58	31
		Хувь	8.0	31.8	38.0	14.5	7.8
Оноо	3.2						


График 1.3. Иргэдийн зүгээс төрийн албанд итгэх байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.5.Иргэд хооронд харилцааны байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн иргэд хоорондоо эвтэй найрамдалтай аж төрдөг бөгөөд аливаа зүй бус явдал харьцангуй бага гэдэгтэй Та санал нийлэх үү?	400	Тоо	72	107	188	22	11
		Хувь	18.0	26.8	47.0	5.5	2.8
Оноо	3.5						



График 1.4.Иргэд хоорондын харилцааны байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.6.Нийгмийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн нийгмийн үйлчилгээний салбар буюу боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл урлаг, спортын үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	33	182	135	21	29
		Хувь	8.3	45.5	33.8	5.3	7.3
Оноо	3.4						



График 1.5. Нийгмийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.7. Хууль сахиулах, аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн хууль сахиулах, аюулгүй байдлын салбар буюу цагдаа, онцгой байдал, шүүх прокуорын үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	55	112	165	59	9
		Хувь	13.8	28.0	41.3	14.8	2.3
Оноо	3.4						

График 1.6.Хууль сахиулах, аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ





Хүснэгт 1.8.Дүүргийн удирдлагуудын үйл

ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын буюу Засаг дарга, Тамгын газар, хороодын удирдлага болон бүртгэл зэрэг үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	81	113	170	19	17
		Хувь	20.3	28.3	42.5	4.8	4.3
Оноо	3.6						



График 1.7. Дүүргийн удирдлагуудын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.9.Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Хот байгуулалт, дэд бүтэц, орчны үйлчилгээ буюу хог хаягдал, газрын алба, цэвэр бохир ус, дулаан цахилгаан, авто замтай холбогдох үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	78	109	132	75	6
		Хувь	19.5	27.3	33.0	18.8	1.5
Оноо	3.4						



График 1.8.Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.10.Эдийн засаг, татвар, бизнесийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Эдийн засаг, татвар, бизнесийн салбар буюу татвар, хөдөлмөр халамжийн болон жижиг дунд бизнесийг дэмжих, ХАА, худалдаа үйлчилгээтэй холбогдох үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	75	99	135	84	7
		Хувь	18.8	24.8	33.8	21.0	1.8
Оноо	3.4						

График 1.9.Эдийн засаг, татвар, бизнесийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 1.11.Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Байгаль орчин, ногоон хөгжил, цаг уурын өөрчлөлттэй холбогдох үйл ажиллагаанд Та хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	400	Тоо	32	108	155	78	27
		Хувь	8.0	27.0	38.8	19.5	6.8
Оноо	3.1						

График 1.10 Байгаль орчин, ногоон хөгжлийн салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ





График 1.11.Хамгийн их сэтгэл ханамжтай буюу сайн үнэлгээ бүхий салбар



График 1.12.Хамгийн бага сэтгэл ханамжтай буюу муу үнэлгээ бүхий салбар



Иргэдийн дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр дүүргийн удирдлага буюу Засаг дарга, түүний Тамгын газар, хороодын Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, иргэний бүртгэл, хот байгуулалт орчны үйлчилгээ буюу хог хаягдал, газрын алба, цэвэр бохир ус, дулаан, цахилгаан, авто замтай холбогдох үйлчилгээ болон үйл ажиллагаа, мөн нийгмийн үйлчилгээ буюу боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл урлаг, спортын үйл ажиллагаа, түүнчлэн хууль сахиулах, аюулгүй байдлын буюу шүүх, прокурор, цагдаа, онцгой байдлын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд иргэдийн сэтгэл ханамж харьцангуй өндөр хувьтай байна.

Иргэд өөрсдийн амьжиргааны түвшин, аливаа эрсдлээс хамгаалагдах байдал болон байгаль орчин, ногоон хөгжил, цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудалд харьцангуй сэтгэл дундуур боловч, ерөнхий дүнгээр дунджаас дээгүүр түвшинд байна. Учир нь иргэдийн дунд учир дутагдалтай гэж үзсэн зарим ажил, үйлчилгээний дундаж оноо 2,0 орчим гарах үзэгдэл байдаг хэдий боловч тус дүүргийн иргэдийн хувьд хамгийн бага оноо 3,1 байгаа нь төдийлөн муу биш гэж үзэхээр байна.

ХОЁР. ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

2.1. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон нутгийн захиргааны байгууллагын 403 албан хаагч хамрагдсанаас нийгмийн үйлчилгээ болон хот байгуулалт, дэд бүтэц, орчны үйлчилгээний чиглэлээр ажилладаг албан хаагчид зонхилж байна. Насны хувьд авч үзвэл 34-41 настай албан хаагчид дийлэнхи хувийг эзэлж, хүйсийн хувьд 67,5 хувь нь эмэгтэй албан хаагчид байна. Ажилласан ажил, туршлагын хувьд 10 жил хүртэлх хугацаанд ажилласан алба хаагч нийт судалгаанд оролцогчдын 51,4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл, жагсаалт

Үзүүлэлт	Шинж байдал	Тоо	Хувь
Албан хаагчийн ажилладаг салбар, чиг үүрэг	Нийгмийн үйлчилгээ /боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, урлаг, спорт/	176	43,7
	Хууль сахиулах, аюулгүй байдал /шүүх, прокурор, цагдаа, зэвсэгт хүчин, онцгой байдал/	30	7,4
	Төрийн болон нутгийн захиргаа /ИТХ, ЗД, Тамгын газар, хорооны ЗД, Ажлын алба/	57	14,1
	Хот байгуулалт, дэд бүтэц, орчны үйлчилгээ /хог хаягдал, газрын алба, цэвэр бохир ус, дулаан, цахилгаан, авто зам/	84	20,8
	Эдийн засаг, татвар, бизнес /татвар, хөдөлмөр халамж, ЖДҮ, ХАА, худалдаа үйлчилгээ/	7	1,7
	Байгаль орчин, ногоон хөгжил /БО, орчны эрүүл ахуй, цаг уурын өөрчлөлт/	7	1,7
	Бусад	7	1,7
Нас	18-25	41	10,2
	26-33	74	18,4
	34-41	110	27,3
	42-49	96	23,8
	50 ба түүнээс дээш	82	20,3
Хүйс	Эрэгтэй	272	67,5
	Эмэгтэй	131	32,5
Төрийн байгууллагад ажилласан жил	0-5 жил	122	30,3
	6-10 жил	85	21,1
	11-15 жил	73	18,1
	16-20 жил	37	9,2
	21-25 жил	29	7,2
	26-30 жил	28	6,9
	31-35 жил	14	3,5
	36-40 жил	8	2
	40-өөс дээш жил	7	1,7

2. Дүүргийн удирдлага зохион байгуулалт, албаны үйл ажиллагаатай холбоотой албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин



Төрийн албан хаагчдын хувьд хуулиар хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж, үр дүнтэй ажиллах эсэх нь тэдний албандаа хандах хандлага, итгэл үнэмшилтэй салшгүй холбоотой. Албан хаагчдын сэтгэл ханамжид дээд шатны албан тушаалтан, удирдлагын бодлого шийдвэр, албан хаагчдын өөрсдийнх нь хууль ёсны эрх ашгийг хамгаалж буй байдал, тэдний үүргээ гүйцэтгэх баталгаа, хүний нөөцийн томилгоо, шагнал урамшуулал, удирдлагын манлайлал зэрэг олон талт үйл ажиллагаа нөлөөлдөг байна.

Судлаачдын зүгээс дүүргийн удирдлагын бүтцийг нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга, түүний Тамгын газар, хороодын Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Ажлын албанаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд албан хаагчид ямар үнэлэмжтэй байгааг тандах зорилгоор 2 төрлийн асуумж оруулсан ба бусад нэгжүүдийг ерөнхийд нь тоймлон авч үзэж, дүнг нэгтгэсэн.

Хүснэгт 2.2. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн удирдлага буюу Засаг дарга, Тамгын газрын болон хороодын Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг уу?	403	Тоо	57	120	183	25	18
		Хувь	14,1	29,8	45,4	6,2	4,5
Оноо	3.4						


График 2.1. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн ИТХ болон Ажлын албаны зүгээс явуулж буй бодлого, үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг уу?	403	Тоо	46	123	181	29	24
		Хувь	11,4	30,5	44,9	7,2	6,0
Оноо	3.3						


График 2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.4. Дүүргийн удирдлагын үйл ажиллагааны нээлттэй байдалд өгсөн үнэлгээ

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүнчлэн дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа Та бүхэнд нээлттэй байдаг гэдэгтэй санал нийлэх үү?	403	Тоо	49	124	165	36	29
		Хувь	12,2	30,8	40,9	8,9	7,2
Оноо	3.3						


График 2.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.5. Дүүргийн албан хаагчдын ур чадвар, шуурхай шударга байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн удирдлага, холбогдох салбарын ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, шуурхай болон шударга байдлын хувьд харьцангуй сайн гэдэгтэй Та санал нийлэх үү?	403	Тоо	43	124	177	36	23
		Хувь	10,7	30,8	43,9	8,9	5,7
Оноо	3.3						


График 2.4. Дүүргийн албан хаагчдын ур чадвар, шуурхай шударга байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.6. Дүүргийн албан хаагчдын эдийн засаг, нийгмийн байталгааг хангах байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн зүгээс төрийн албан хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	403	Тоо	33	93	185	50	42
		Хувь	8,2	23,1	45,9	12,4	10,4
Оноо	3.1						


График 2.5. Дүүргийн албан хаагчдын эдийн засаг, нийгмийн байталгааг хангах байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.7. Иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд өгсөн үнэлгээ

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн зүгээс иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмж сайн байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	403	Тоо	45	124	174	34	26
		Хувь	11,2	30,8	43,2	8,4	6,5
Оноо	3.3						


График 2.6. Иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.8. Албан хаагчийг идэвхижүүлэх, мотивацийн байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн хэмжээнд албан хаагчийг дэвшүүлэх, шагнах, урамшуулах болон хариуцлага тооцох тогтолцоо шударга явагддаг гэдэгтэй Та санал нийлэх үү?	403	Тоо	34	106	183	42	38
		Хувь	8,4	26,3	45,4	10,4	9,4
Оноо	3.1						


График 2.7. Албан хаагчийг идэвхижүүлэх, мотивацийн байдалд өгсөн үнэлгээ



Хүснэгт 2.9.Авлига, хүнд суртал, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээний тоо, хувиар

Асуумж	Судалгаанд оролцсон хүний тоо	Дундаж үнэлгээ	Маш их /5/	Их /4/	Дунд зэрэг /3/	Бага зэрэг /2/	Огт үгүй /1/
Дүүргийн хэмжээнд авлига, хүнд суртал гаргахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахих, бусдад хүндэтгэлтэй хандах зэрэг байгууллагын соёл төлөвшсөн гэдэгтэй Та санал нийлэх үү?	403	Тоо	37	117	177	41	31
		Хувь	9,2	29,0	43,9	10,2	7,7
Оноо	3.2						

График 2.8.Авлига, хүнд суртал, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээ



Дээрх асуумжуудын үр дүнг баталгаажуулах, хүлцэх алдааны хэмжээ буюу судалгааны үр дүнгийн “гажилт” зэргийг тодорхойлох зорилгоор тухайн олон хариулттай буюу 3 хүртэлх хувилбарыг сонгож, хамгийн сайн буюу хамгийн тааруу гэж үзсэн чиг үүргийн хэрэгжилтийг зааж нэрлэхийг хүссэн ба уг асуумжийн хүрээнд дараах графикт харуулсан хувь хэмжээгээр тус тус сонголтууд хийгдсэн байгаа нь дээрх асуумжуудын үр дүнтэй ойролцоо байна.

График 2.9.Хамгийн их сэтгэл ханамжтай буюу сайн үнэлгээ бүхий салбар



График 2.10.Хамгийн бага сэтгэл ханамжтай буюу муу үнэлгээ бүхий салбар



ДҮГНЭЛТ

1.Иргэдийн дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр дүүргийн удирдлага буюу Засаг дарга, түүний Тамгын газар, хороодын Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, иргэний бүртгэл, хот байгуулалт орчны үйлчилгээ буюу хог хаягдал, газрын алба, цэвэр бохир ус, дулаан, цахилгаан, авто замтай холбогдох үйлчилгээ болон үйл ажиллагаа, мөн нийгмийн үйлчилгээ буюу боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл урлаг, спортын үйл ажиллагаа, түүнчлэн хууль сахиулах, аюулгүй байдлын буюу шүүх, прокурор, цагдаа, онцгой байдлын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд иргэдийн сэтгэл ханамж харьцангуй өндөр хувьтай байна.

2.Иргэд өөрсдийн амьжиргааны түвшин, аливаа эрсдлээс хамгаалагдах байдал болон байгаль орчин, ногоон хөгжил, цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудалд харьцангуй сэтгэл дундуур боловч, ерөнхий дүнгээр дунджаас дээгүүр түвшинд байна. Учир нь иргэдийн дунд учир дутагдалтай гэж үзсэн зарим ажил, үйлчилгээний дундаж оноо 2,0 орчим гарах үзэгдэл байдаг хэдий боловч тус дүүргийн иргэдийн хувьд хамгийн бага оноо 3,1 байгаа нь төдийлөн муу биш гэж үзэж болно.

3.Төрийн албан хаагчдийн хувьд ч мөн адил нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ажлын алба, нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга, Тамгын газар, хороодын Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, үйл ажиллагаа, ялангуяа иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа харьцангуй сайн явагддаг гэж дүгнэхээр байна.

4.Харин албан хаагчдын хувьд өөрсдийн эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, шагнаж урамшуулах болон хариуцлага тооцох тогтолцоо, түүнчлэн авлигаас ангид байх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих зэрэг байгууллагын соёл тогтсон асуудалд харьцангуй сэтгэл ханамжгүй байна. Энэ нь тухайн судалгаанд хамрагдагсад өөрсдөд чиглэсэн үйлчилгээг илүү хүсэх, гадагш чиглэсэн буюу өөрсдийн зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг илүү өндрөөр үнэлэх хандлагыг илэрхийлж байх магадлалтай хэдий ч энэ асуудлаар сэтгэл ханамжийг дээшлүүлэхтэй холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байж болно гэсэн үг биш юм.

5.Дээрх судалгаанд хамрагдсан иргэд, албан хаагчдын аль аль нь тус дүүргийн эдийн засаг, татвар, бизнесийн орчинд төдийлөн сэтгэл ханамжтай бус байх хандлагатай бөгөөд фокус ярилцлагад оролцсон, чөлөөт асуулт хариултуудад ч энэ төрлийн сэтгэгдлүүд тодорхой хэмжээнд гарч байгааг анхаарч, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийг тэлэх, бизнесийн орчныг сайжруулах талаар тусгайлан судалгаа хийж, урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй уялдуулан, үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах, энэ талаар иргэдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг сайтар хийх шаардлагатайг харуулж байна.

Энэхүү судалгааг хийсэн судлаачдын багийн ашигласан аргачлал нь тухайн судалгаанд хамрагдагсдын хувьд сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж байгаа бөгөөд уг судалгааны дүнгээр бусад аймаг, дүүрэгтэй харьцуулалт хийх буюу сэтгэл

ханамжгүй байгаа нь тухайн чиг үүргийн байгууллага, албан тушаалтны ажил үйлчилгээ доголдсон зэргийг шууд илэрхийлж байгаа гэж үзэх нь учир дутагдалтай бөгөөд нийт дунджийн хувьд 3.0-аас ямагт дээгүүр байгаа нь 50 хувиас их буюу сэтгэл ханамж хэвийн, зарим тохиолдолд өндөр хувьтай гэж үзэхээр байна.

ЗӨВЛӨМЖ

1.Иргэд эдийн засаг, нийгмийн баталгааг хангах, татвар, бизнесийн орчныг илүү сайжруулах, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /тухайлбал, орон сууцжуулах, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хүнс барааны зах ажиллуулах гэх мэт/-эд чиглэсэн ажил, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

2.Албан хаагчдыг шагнаж урамшуулах, хариуцлага тооцох, дээд шатны байгууллага, албан тушаалтны зүгээс улс төрийн шинжтэй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог зөв, оновчтой хэлбэрээр зохион байгуулах /тухайлбал, үйлдвэрчний эвлэлүүдийг дэмжих, мэргэжлийн холбоодын оролцоог сайжруулах гэх мэт/;

3.Зарим төрлийн зайлшгүй үйлчилгээ /тухайлбал, хотын доторх болон хот орчмын нийтийн тээвэр, цэцэрлэгжүүлэлт гэх мэт/-г сайжруулах, энэ чиглэлээр иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулах, авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн явц, хүлээгдэж буй үр дүнгийн талаар тогтмол мэдээлэх.

